



**НИЙСЛЭЛИЙН
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 5/19

Улаанбаатар хот

Г.Оюунтөмөрийг ажлаас чөлөөлж,
ажилд томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2, Хан-Уул дүүргийн Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.1, Хан-Уул дүүргийн Усан спорт, сургалтын төв ОНӨУТҮГ-ын дүрмийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хан-Уул дүүргийн Эко ахмадын сувилал орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Ганбатын Оюунтөмөрийг 2023 оны 3 дугаар сарын 30-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлж, мөн өдрөөс эхлэн Хан-Уул дүүргийн Усан спорт, сургалтын төв ОНӨУТҮГ-ын захирлаар томилсугай.

2. Г.Оюунтөмөрийн ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Цэрэн	Засаг даргын орлогч
Гишүүд:	Ч.Байгаль	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
	Ч.Эрдэнэчимэг	Хан-Уул дүүргийн Эко ахмадын сувилал ОНӨААТҮГ-ын нягтлан бодогч
	Д.Саранчимэг	Хан-Уул дүүргийн Усан спорт, сургалтын төв ОНӨУТҮГ-ын нягтлан бодогч

Нарийн бичгийн дарга: Б.Мархагүл Архивч

3. Г.Оюунтөмөрийн үүрэгт ажлыг 2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр багтаан хүлээлцэхийг ажлын хэсэг (Б.Цэрэн)-т, албан тушаалын нэг сарын үндсэн цалинг /ТҮ-9/ 967,621 (есөн зуун жаран долоон мянга зургаан зуун хорин нэгэн) төгрөгөөр тогтоож, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд заасан нэмэгдлийг нэг сарын үндсэн цалингийн 40 хувиар тооцож сар бүр олгохыг Хан-Уул дүүргийн Усан спорт, сургалтын төв ОНӨУТҮГ-ын нягтлан бодогч (Д.Саранчимэг)-д тус тус даалгасугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан Хан-Уул дүүргийн Засаг даргын 2022 оны Б/64 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.АЛДАРЖАВХЛАН

170140088